



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 182

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус үндэслэн “Өвөрхангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 242,040,000.00 (хоёр зуун дөчин хоёр сая дөчин мянган) төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны А-1/66 дугаар албан даалгаврын биелэлт 85.0 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байх тул албан даалгаврын биелэлтийг ханган ажиллахыг “Өвөрхангай АЗЗА” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Д.Лхам-Оролмаад үүрэг болгосугай.

2.“Өвөрхангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3.“Өвөрхангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөсүгэй:

3.1. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал болон тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах;

3.2.Компанийн батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үндэслэн тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах;

3.3.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдалд хяналт тавьж ажиллах үүргээ хангалтгүй биелүүлсэн “Өвөрхангай АЗЗА” төрийн өмчит хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцох.

4.“Өвөрхангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Лхам-Оролмаад дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

4.1.Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний толовлогоо боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

4.2.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, гүйцэтгэх захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээгээр олгосон эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулах, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд туссан зардлаас бусад зардлыг санхүүжүүлэхгүй байх;

4.3.Өвөрхангай аймаг, Хайрхандулаан сум, Өндөр толгойт газарт байрлалтай шуурхай ажлын хэсгийн байрны газар эзэмших эрхийг баталгаажуулах;

4.4.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлснээс Улсын төсөвт төвлөрүүлэх хувь хэмжээ тогтоох тухай” 49 дүгээр тогтоолын дагуу 2021 онд төрийн өөрийн өмчийн эд

132001512

хөрөнгийг түрээслүүлснээс олсон орлогын 40 хувь, 192,000.00 (нэг зуун ерэн хоёр мянган) төгрөгийг 2 дугаар улиралд багтаан Улсын төсөвт төвлөрүүлэх;

4.5.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдлөг болгон ажиллах, зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, төрийн өөрийн өмчит бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;

4.6.Машин тоног төхөөрөмжийн дансанд бүртгэлтэй 15 нэр төрлийн, 1,043.79 сая төгрөгийн балансын үнэтэй механизмыг тээврийн хэрэгслийн дансанд хүнд машин механизм төрлөөр ангилан бүртгэх;

4.7.Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 11 ширхэг 320.95 сая төгрөгийн балансын үнэ бүхий барилгын элэгдлийг 2018 онд дахин үнэлгээгээр тогтоосон ашиглах хугацаагаар тооцож элэгдүүлэх, санхүүгийн программд өөрчлөлтийг оруулах;

4.8.Элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох, саналыг боловсруулан Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

4.9.Эзэмшигчийн нэр зөрүүтэй 3 ширхэг, 44.29 сая төгрөгийн балансын үнэ бүхий тээврийн хэрэгслийг компанийн нэр дээр шилжүүлэх;

4.10.Худалдан авах ажиллагаанд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөн ажиллах, төлөвлөгөөнд тусгагдаагүй бараа материал, үндсэн хөрөнгө бэлтгэхгүй байх;

4.11.Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй үндсэн хөрөнгийг худалдан авч эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэдэг зөрчлийг давтан гаргахгүй байх;

4.12.Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг үндэслэн компанийн мөнгөн кассын үйл ажиллагааны журам баталж, мөрдөн ажиллах;

4.13.Тогтоолын биелэлтийг 2022 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

5.Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх.

6.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн
28 дугаар тогтоолын хавсралт



“Өвөрхангай АЗЗА” төрийн өмчит компанид хийсэн
шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах
арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил дутагдлын утга	Мөнгөн дүн /сая төгрөгө өр/	Зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт
1	Худалдан авалтын төлөвлөгөөнөөс гадуурх худалдан авалт болон төсөвт өртгөөс хэтрүүлэн авсан худалдан авалт	194.41	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг болон Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөх, тайлагна журам”-ыг мөрдөж ажиллах.
2	Анхан шатны баримтын /и-баримт/ бүрдэлгүй ажил үйлчилгээ.	39.41	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсгийг мөрдөж ажиллах.
3	Зөвшөөрөлгүй бэлтгэсэн хөрөнгө	4.44	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийг, батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтыг мөрдөж ажиллах.
4	Замчдын баярын арга хэмжээнд болон үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй үйл ажиллагааг санхүүжүүлсэн.	3.59	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх хэсгийг болон Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах.
5	Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө бусдад түрээслүүлэн, олсон орлогоос Улсын төсөвт төвлөрүүлээгүй.	0.19	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах.
6	Өвөрхангай аймаг, Хайрхандулаан сум, Өндөр толгой байрлалттай шуурхай ажлын хэсгийн байрны газрын эрхийг баталгаажуулан аваагүй.	-	Газрын эрхийг баталгаажуулан авах, 2022 оны санхүүгийн тайланд үнэлж, тусгах ажлыг зохион байгуулах.

7	Барилга байгууламжийн элэгдлийг дутуу тооцсон	-	Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалыг мөрдөж ажиллах, бүртгэлийг засаж залруулах.
8	Бичиг баримтын зөрчилтэй 3 тээврийн хэрэгслийг санхүүгийн тайланд тусгасан	-	3 тээврийн хэрэгслийн бичиг баримтын зөрчлийг арилгах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах.
Нийт хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын дүн		242.04	(Хоёр зуун дөчин хоёр сая дөчин мянга)

--o0o--